



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ТӨРӨЛ БҮРИЙН МАРКИЙН АВТОМАШИНЫ
ГАРААШИНД БАЙРЛАХ БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ ШАТАХУУН
ТҮГЭЭХ СТАНЦЫН ИХ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2024.08.21

Дугаар ...

Орхон аймаг

№	Нэр	Төлөвлөлтөд тусгах ажил
1	Ажлын нэр	ТБМАГ. Шатахуун түгээх станц №2-н зураг төсөл боловсруулах ажил
2	Зураг төсөл боловсруулах үндэслэл	ХАБЭА-н 2019 оны өдрийн №107/09 тоот акт, албан шаардлага, 2019 оны ГТУХАБ-ын заавал биелүүлэх №01/94 тоот албан шаардлага
3	Байршил	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 13-р баг, Баянцагаан баг ПДУ-гийн урд ШТС, 397 тоот
4	Байгууламж ба орчны тохижилт	<ol style="list-style-type: none">1. Эдэлбэр газрын хэмжээ 1.1 га талбайн хашаа, хайс, орчны тохижилтыг төлөвлөх,2. Түгээгүүрийн саравчийг засварлах,3. Түгээгчийн байрыг засварлах, гадна өнгөлгөөг металл хавтангаар төлөвлөх,4. Орчны зам талбай, зогсоолыг асфальт бетон хучилтаар төлөвлөх,5. ШТС-ын автомашины орох гарах гарцыг стандартын дагуу шинээр төлөвлөх,6. ШТС-ын талбайн борооны ус зайлуулах хоолой, үерийн хамгаалалт төлөвлөх,
5	Автоцистернээс шатахуун хүлээн авах байгууламж	<ol style="list-style-type: none">1. Сав тус бүр лүү газрын тосны бүтээгдэхүүнийг урсгалаар хүлээн авахаар төлөвлөх,2. Буулгах болон технологийн худгийн тагийг нээж, хаагдах үеийн түгжээтэй, оч үсэрдэггүй материалаар гадна орчны бохирдол, ус чийг орохоос бүрэн сэргийлсэн байдлаар төлөвлөх,3. Автоцистерний шатахуун буулгах зогсоол нь газардуулгатай, мөн ослын савруу холболт хийгдсэн байх,4. Буулгах худгийг ослын савруу холбосон байх5. Буулгах хоолойн шүүртэй байх,
6	Шатахуун хадгалах сав	<ol style="list-style-type: none">1. А92, А95, ДТ зэрэг 3 төрлийн бүтээгдэхүүн хадгалах,

		<ol style="list-style-type: none"> 2. Бүтээгдэхүүн тус бүр 2 ширхэг 25 метр кубийн багтаамжтай давхар ханатай, бмм-с багагүй ханын зузаантай, нийт 6 ширхэг гад савыг далд суурилуулахаар төлөвлөх, 3. Сав суурилуулах талбайн хөрсөнд сорилт шинжилгээ хийх, 4. Ослын савны багтаамж нь 10 метр кубээс багагүй байна, 5. Савны амьсгалах хавлагийг газрын төвшнөөс 4м-с багагүй өндөр байх, 6. Савыг ул бетон суурьтай бэхлэх ган бүслүүр болон тулгууртай байх, 7. Савны гадна орчны зэврэлтээс хамгаалахад ашиглах материалыг тодорхой техникийн шаардлагыг тусгаж өгөх, 8. Сав тус бүр үнэртүүлэгч хоолойтой байх, 9. Сав тус бүр нь өөр дээрээ гүний сорох насостой байх, 10. Савыг ус, чийгээс тусгаарлах түрхлэг болон будгийн техникийн үзүүлэлтийг тусгайлан заасан байх, 11. Саван дахь бүтээгдэхүүний төвшнийг гар аргаар хэмжих зориулалттай шугаман метрийн чиглүүлэгчтэй байх,
7	Шатахуун түгээгүүр	<ol style="list-style-type: none"> 1. 2 ширхэг 4 хошуутай түгээгүүр (70-120 л/мин)-ийг ашиглана. (тус түгээгүүр нь Veeder Root Horizon II) 2. Сав тус бүртэй холболттой байхаар төлөвлөх, 3. Хоолойн аюулгүйн таславч хавлагтай,
8	Технологийн шугам хоолой	<ol style="list-style-type: none"> 1. Хөрс, талбайн уснаас найдвартай хамгаалах ба технологийн шугам хоолой, түүний холбох хэрэгслүүдийг давхар ханатай полиэтилен (UPP) хоолойгоор төлөвлөх, 2. Технологийн худгийн шугам хоолойн оролт бүр уян жийрэгтэй байх, 3. Түгээгүүрүүд нь шатахуун хадгалах торхыг сэлбэн холбох боломжтойгоор төлөвлөх, 4. Технологийн шугам хоолойг ашиглалтын явцад сэлгэн залгах, нөөц шугамтай байхаар төлөвлөх,
9	Технологийн ажиллагааны автоматжуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Савны түвшин, температур, хувийн жин, литр, массыг хэмжих, халилтаас сэргийлэх, шүүрлийг мэдээлэх автомат систем суурилуулах байна, (Тус төхөөрөмжийг <i>Veeder Root нүүсийн TLS 450Plus байхаар төлөвлөнө</i>). 2. Шатахуун түгээх станцыг хэмжилт тооцоо, орлого зарлагын бүртгэл, тайлан боловсруулах автоматжуулсан программ хангамж төлөвлөх, (<i>Veeder Root нүүсийнх байх</i>). 3. Гал унтраах бие даасан автомат систем төлөвлөх, (<i>Системийн дохиолон залгах төхөөрөмж УПС101-72Э, гар залгуур УПС101-Р, гал унтраах төхөөрөмж нь</i>

		<p><i>МПП(Н)-10(СТ)-И-ГЭ-У2 болон МПП(Н)-9И-ГЭ-У2 байх)</i></p> <p>4. Түгээгүүр нь захиалагчийн баталсан техникийн даалгаварын шаардлагыг хангасан карт унших системтэй байна.</p> <p>a. Карт уншигч нь 13,56 Mhz давтамж дээр уншдаг байх (Mifare classic IC ISO/IEC 14443 Type A төрлийн карт унших)</p> <p>b. TCP/IP сүлжээнд холбогддог байх. Rj-45 оролттой байх.</p> <p>c. Эрдэнэт үйлдвэрийн картын системтэй холбогдон ажиллах боломжтой нээлттэй API эсвэл SDK-тай байх.</p> <p>d. Карт уншигч IP67 хамгаалалттай байх.</p> <p>e. Карт уншигчуудын мэдээллийг нэгдсэн контроллёр дээр авдаг байх. Контроллёрыг нөөц тэжээлийн үүсгүүрт холбодох байх.</p> <p>f. Нөөц тэжээлийн үүсгүүр /UPS/ тэй байх APC3300VA.g. Сүлжээний switch Cisco catalyst C9200-24PXG</p> <p>5. Одоо ашиглагдаж буй камерын системийн иж бүрдлүүдийг шилжүүлэх, буцаан угсрах ажлуудыг төлөвлөх.</p> <p>6. Халилтаас сэргийлэх тоноглолтой байх. Тус тоноглол нь савны 95 хувийн дүүргэлтэд хүрэх үед бүрэн хаагддаг байх. Давхар ханатай савны хана хоорондын битүүмжлэлийг хянах мэдрэгчтэй байх, Хөрсөнд газрын тосны бүтээгдэхүүн нэвчсэн эсэхийг хянах мэдрэгчтэй байх,</p>
10	Ажлын зурагт тусгах бусад ажлууд	<p>1. Аянга, газардуулга болон тоног төхөөрөмжийн газардуулгыг төлөвлөх,</p> <p>2. Чанга яригчийн байршил, тоо хэмжээ,</p> <p>3. Гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн иж бүрдлийн байршил тоо хэмжээ байршил,</p> <p>4. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээг ISO 7010 дагуу гүйцэтгэж, байршил, хэмжээ, шаардлагатай тоо зэргийг зураг төсөлд тусгасан байх,</p>
11	Зураг төсөлд тавигдах шаардлага ба түүний иж бүрдлүүд	<p>1. Ерөнхий төлөвлөгөө, (<i>Дэвсгэр зураг, байршлын схем, одоогийн байдал, өндөржилт</i>)</p> <p>2. Барилга архитектур, (<i>3 хэмжээст зургийн хамт</i>)</p> <p>3. Барилгын бүтээц, (<i>ШТС-ын хадгалах сав, шугам хоолой, гадна орчны буулгах ажлын тоо хэмжээний хамт</i>)</p> <p>4. Холбоо дохиолол, (<i>галын дохиолол, камер, холбоо, интернэт сүлжээ</i>)</p> <p>5. Төхөөрөмжийн цахилгаан холболт, шилжүүлгийн зураг</p>

		<ol style="list-style-type: none"> 6. Аянга хамгаалалт, газардуулгын байгууламж (тоног төхөөрөмжийн газардуулгын хамт) 7. Гадна цахилгаан хангамж, (БД 43-101-03-н 7.1, 7.2 бүлгийн дагуу төлөвлөсөн байх) 8. Технологийн хэсэг 9. Автомат удирдлагын систем 10. Гал түймэр, гамшгаас аврах ажиллагааны гарцын схемий хамт хийх, 11. Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, (Суурилагдсан тоног төхөөрөмж тус бүрийн техникийн шаардлага болох ISO болон MNS стандарт, хүчин чадал, овор хэмжээ, онцлог шинж чанар, материалын төрөл тус бүрийг тусгайлан заах. Үүнд: Гал унтраах системийн гал унтраагуур, галын дохиоллын удирдлагын блок болон түүний дагалдах хэрэгслүүд, дөл мэдрэгч, утаа мэдрэгч, савны автомат түвшин хэмжигч, савны түвшин хэмжигчийн удирдлагын блок, Давхар ханатай савны хана хоорондын битүүмжлэлийг хянах мэдрэгч, Хөрсөнд газрын тосны бүтээгдэхүүн нэвчсэн эсэхийг хянах мэдрэгч, компьютер Түгээгүүр, Шатахуун хадгалах сав, чанга яригчийн иж бүрдэл, цахилгаан холболтод ашиглах кабелийн төрөл, Технологийн шугам хоолойд ашиглах материал, түүний холбох хэрэгсэл, амьсгалах хавхлаг, Үл буцаах бүх хаалтууд орно.) 12. Иж бүрдэл тус бүрийн төсвүүд (Estimator-Pro болон түүнтэй дүйцэхүйц программ хангамж дээр хийсэн байх) багтана. 13. Зураг төслийн бүлэг тус бүрд боловсруулахад ашигласан Монгол улсын дүрэм, олон улсын болон дотоодын стандарт, БХБД-н жагсаалтыг тайлбар хэсэгт тусгайлан зааж тусгасан байх,
12	Захиалагч байгууллагад бүрдүүлэн хүлээлгэн өгөх баримт бичиг	<ol style="list-style-type: none"> 1. Зураг төсөл болон төсөвт экспертизийн магадлал хийлгэсэн байх, 2. Ажлын зургийг Онцгой байдлын газраар хянуулсан байх, 3. Ажлын зургийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулсан байх, 4. Зураг төслийг 4 хувь үйлдэх ба цаасан болон цахим хэлбэрээр (CD-нд хуулбарласан). Эрдэнэт үйлдвэр архив, Гүйцэтгэгч байгууллага, захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.

ЗӨВШИЛЦСӨН:

ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ, АХМАД



Х.ГАНБАТ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ТҮМЭН-ӨЛЗИЙ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА-
ЕРӨНХИЙ ЭРЧИМ ЗҮЙЧ

Л.АРИУНБОЛД

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МӨНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЖАВХЛАНБАТ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ГАНСҮХ

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БАТБАЯР

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ИНЖЕНЕР

Д.ЭНХ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

АВТОТЭЭВРИЙН ЦЕХИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Д.ЦОЛМОН

АВТОТЭЭВРИЙН ЦЕХИЙН
ҮЙЛДВЭР ТЕХНИКИЙН
ТОВЧООНЫ ДАРГА

Н.ГАНБОЛД

АВТОТЭЭВРИЙН ЦЕХИЙН
ТЭРГҮҮЛЭХ ЭРЧИМ ЗҮЙЧ

А.БАТДОРЖ

АВТОТЭЭВРИЙН ЦЕХИЙН

ШАТАХ, ТОСЛОХ МАТЕРИАЛЫН
АГУУЛАХЫН ЭРХЛЭГЧ

Б.ОТГОНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

АВТОТЭЭВРИЙН ЦЕХИЙН
ҮЙЛДВЭР ТЕХНИКИЙН
ТОВЧООНЫ ЗОХИОН БҮТЭЭГЧ, БАРИЛГЫН
АШИГЛАЛТЫН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Г.БИЛГҮҮН